

СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН  
ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-20

---

*1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн  
бэлтгэл ажлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл  
сонсох*

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны  
03 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл***

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны дарга Ж.Батсуурь ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 3 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 13 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

***Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын  
талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, мөн хорооны Мэдээлэл, технологийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Лхамжав, мөн төвийн референт А.Банзрагчдорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Төгөлдөр, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ж.Батсуурь нарын тавьсан асуулгад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаарх Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 16 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 11 минут үргэлжилж, ирвэл зохих 3 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн хувийн ирцтэйгээр 16 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,  
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
15 цаг 13 минут.

### СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган эхлээд мөн өнөөдөр 3 сарын 19-ний өдрийн Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн дэд хорооны хуралдаан хуралдахад нийт гишүүд, Дэд хорооны гишүүд бүгд ирсэн учраас хуралдааныг эхлүүлэе гэж.

Энэ Дэд хорооны даргаар томилогдоод анхны хурал байгаа. Тэгэхдээ энэ жил бол Улсын Их Хурлын сонгуультай маш чухал жил. Намрын чуулганы сүүлчээр Дэд хорооны гишүүд солигдож, даргаар томилогдсоноос хойш анхны хурал байгаа.

Энэ чуулганы явцад энэ ер нь Монгол Улсад Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн, орон нутгийн сонгуулийг явуулахад төрийн бүтцийн хэмжээнд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, баг, хороо сонгуулийнхаа хэллэгээр тойргийн хороо, хэсгийн хороонд ямар бэрхшээл тулгардаг юм бэ? Ард иргэдээс ер нь ямар санал, гомдол ирдэг юм бэ? Өмнөх 92 оноос хойших 8 удаагийн Улсын Их Хурлын болон түүнтэй тэнцэх орон нутгийн сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулиудад ирж байсан алдаа оноог та бүхэн орон нутгаас, анхан шатаас авч ирүүлнэ үү гэсэн ийм бичгийг орон нутгийн ИХ-д хүргэсэн байгаа. Тэгээд бараг үндсэндээ бүх аймгуудаас бичиг ирсэн. Яг үнэнийг

хэлэхэд танилцаж амжаагүй байна. Тойрогт ажиллаж байгаад бид бүхэн урьд шөнө ирсэн.

Ер нь цаг шахааж ажиллах шаардлагатай учраас та бүхний мэдээллийг бид бүхэн бас сонсоод өнөөдрийн хурлаар, дээр нь манай Дэд хорооны гишүүдээс асуух зүйл байвал асуугаад, мөн бид нар санал бодлоо хэлээд өнөөдөр ирж та нарын бүхэн мэдээлэл буюу орон нутгаас ирсэн зүйлийг бас мэдээлэл гэж хараад дараагийн хурал болтол ямар ажлууд хиймээр байна, үүрэг чиглэлүүдээ хувааж аваад өнөөдрийн хурлыг өндөрлөе гэж ингэж бодож байна. Тэгэхлээр өнөөдрийн хуралд ирсэн хүмүүсийг танилцуулъя.

Дэлгэрнараран Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Д.Дэлгэрсайхан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Т.Төгөлдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга, Л.Лхамжав Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, технологийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, А.Банзрагчдорж Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, технологийн төвийн референт, Н.Наранцэцэг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын ахлах гэсэн ийм бүрэлдэхүүн ирсэн байна. Өөр орлож ирсэн юм уу, нэмж ирсэн хүмүүс байна уу? Мөн юун дээр ирсэн тэр бас улс төрийн намуудад бичиг явуулсан. Түүнээс бас асууж лавлах зүйлүүд байна уу гэсэн ийм зүйлүүд байгаа. Зарим улсууд бол дэд хэсэг маягтай болж мэдээллийг бас давхар сонсьё гэж, сонсохлоор мэдээлэл авахаар бас зарим хүмүүс хүрэлцэн ирсэн байгаа гэдгийг та бүхэнд танилцуулъя.

**Ингээд эхний ээлжид Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаарх холбогдох байгууллагын мэдээллийг сонсьё.**

Одоо шууд Сонгуулийн ерөнхий хороо юу? Үүнийг унших шаардлага байна уу, байхгүй юу? Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран дарга мэдээллээ өгнө үү.

**П.Дэлгэрнаран:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд сонгуулийн автоматжуулсан системийн техникийн хэрэгсэл хэрэглэх бэлтгэл ажлын танилцуулгыг хийе.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21 өдрийн 113 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмж хэрэглэхийг зөвшөөрсөн.

Сонгуулийн ерөнхий хороо, түүний дэргэдэх Мэдээлэл, технологийн төвөөс санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд хэрэглэх сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, сонгуульд бэлтгэх ажлыг Монгол Улсын Их Хурлын дээрх тогтоол болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль тогтоомжид заасны дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэн техникийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллаж байна.

Тухайлбал, нэгдүгээрт, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдэлд хамаарах 9 төрлийн багц тоног төхөөрөмжид техникийн үзлэг, засвар үйлчилгээг 2023 оны 4 дүгээр улиралд бүрэн дуусгаж, хийж бэлтгэлээ.

Сонгуулийн техникийн үзлэгийн дүнд 2012 онд худалдан авсан 257 ширхэг санал тоолох төхөөрөмжийг журмын дагуу акталж, улмаар Хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвөөс 507 ширхэг санал тоолох төхөөрөмжийг иж бүрдлийн хамт худалдан авах ажиллагааг зохион байгуулж хийлээ.

Нөхөн бүрдүүлэлт болон техникийн үзлэг шалгалтыг бүрэн хийснээр нийт 3000 ширхэг санал тоолох төхөөрөмжийг ээлжит сонгуульд ашиглахад бэлэн болголоо. Мөн тоног төхөөрөмжийн нөхөн бүрдүүлэлт хийсэнтэй холбоотойгоор сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагааг хариуцан ажиллах 4 албан хаагчийг уг төхөөрөмжийг нийлүүлэгч компани болох АНУ-ын Доминион вотинг /dominion voting/ систем компанийн сертификат олгох сургалтад хамруулж, мэргэшүүлэх ажлыг зохион байгууллаа.

2.Мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийг шинэчлэн тодорхойлох, эрсдэлт хүчин зүйлийг арилгах зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооноос Тагнуулын ерөнхий газарт хүсэлт гарган холбогдох зөвлөмжийг авсан.

Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн уг зөвлөмжийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны кибер аюулгүй байдлын бодлого, кибер аюулгүй байдлыг хангах журам, онцгой байдлын үед мэдээллийн систем сүлжээний тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах, мөрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар сүлжээний дэд бүтцийн тархалтаас хамааралтайгаар 461 санал авах байрнаас санал хураалтын үр дүнг зөвөөрлөж дамжуулж байсан. Тус хорооны Мэдээлэл, технологийн төвөөс сүлжээний дэд бүтцийн үндсэн судалгааг хийхэд өнөөдрийн байдлаар 223 хэсгийн

хорооны байрлалд үүрэн холбооны сүлжээ байна. Эдгээр байрлалаас санал хураалтын дүнг шууд дамжуулах техникийн нөхцөл бүрдүүлэх зорилгоор сүлжээний дэд бүтцийн судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

4. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд ашиглах сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан [www.e-election.mn](http://www.e-election.mn) цахим системийг ашиглалтад оруулж, сонгуулийн автоматжуулсан системийн бүх төрлийн тоног төхөөрөмжийн хөдөлгөөний бүртгэл, ашиглалтын мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх боломжийг бүрдүүлээ. Энэхүү систем нь тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэлийг цахимаар хөтлөхөөс гадна бүх шатын сонгуулийн хороодод ажиллах төрийн албан хаагчдад цахимаар сургалт явуулах, сонгуулийн хороодоос сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад үүсдэг бүртгэлийн ажлыг цахимжуулах, мэдээллийн цахим нэгдсэн сан үүсгэх ач холбогдолтой юм.

Ингээд би сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгслийг сонгуульд бэлтгэх ажлын төлөвлөгөөг ажлын явцыг товч танилцууллаа.

**Ж.Батсуурь:** Дэлгэрнараран даргад баярлалаа. Мэдээллээ нэгмөсөн авах зорилгоор дараагийн байгууллагын мэдээллийг сонсчихъё гэж бодож байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны, өшөө энэ чинь юу билээ? Эхнийх нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын танилцуулгыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дэлгэрсайхан дарга хийнэ. Дэлгэрнараран дарга цаасаар өгнө тийм ээ? Тэгье. Одоо авчихъя. Өнөөдөр саяын энийг хэлж байна уу тээ Дэлгэрсайхан дарга?

**Д.Дэлгэрсайхан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлж

байгаа үйл ажиллагааны талаар Ерөнхий газрын дарга Дэлгэрсайхан миний бие танилцуулгыг хүргэж байна.

2012 он буюу шинэчилсэн бүртгэлд хамрагдсанаас хойш улсын бүртгэлийн байгууллага ээлжит 10, ээлжит бус, дахин, нөхөнтэй нийлээд энэ 22 сонгуулийг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх хуульд заасан 8 гол чиг үүрэг байдаг. Энэ маань яг өнөөдөр бид нарын хийж байгаа ажлаар 112 ажилбар болж, энэ 112 ажилбарыг хийж эхлээд байна. Үүнд сонгуулийн хэсэг байгуулах, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулга хүргүүлэх, итгэмжлэгдсэн ажилтантай холбоотой, мөн сонгууль, сонгогчдын нэрийн жагсаалтад холбогдсон гомдлыг шийдвэрлэх, мөн журам боловсруулах, сонгогчийг ишлжих, иргэний ишлжилт хөдөлгөөнийг зогсох, зөвөрийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах, санал авах байранд санал авах ажиллагаа гэсэн энэ 8 үйл ажиллагаа байдаг юм. Энэ 8 үйл ажиллагаа өнөөдөр төлөвлөгөөгөөр задраад 115 ажлыг бид нар төлөвлөөд хийж гүйцэтгэж байна.

24 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах төлөвлөгөө маань гарсан. Үүн дээр нэгдүгээрт нь Сонгуулийн ерөнхий хорооноос ажлын цаглаврыг баталж өгсөн байгаа. Энэ ажлын цаглавар 1 сарын 9-ний өдөр цаг хугацааны хуваарь маань гарсан.

Хоёрдугаарт нь 2023 оны 11 сарын 6-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллага дээр ажлын хэсэг гарсан. Энэ ажлын хэсгээр 115 ажилбар бүхий төлөвлөгөөг баталсан. Одоо хэрэгжүүлж явж байна. Энэ төлөвлөгөөтэй холбоотойгоор төсөв, санхүүгийн чиглэлээр дэд төлөвлөгөө, сургалт сурталчилгааны чиглэлээр дэд төлөвлөгөө, мэдээлэл, технологийн чиглэлээр дэд төлөвлөгөө буюу 3 дэд төлөвлөгөөтэй 115 ажил үүргийнхээ

төлөвлөгөөгөөр бид бүхэн ажиллаж байна. Ингээд 6 хийсэн ажлыг танилцуулъя.

Нэгдүгээрх нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын энэ хамтарсан тушаал байгаа ажлын хэсэг байгуулсан, Тагнуулын ерөнхий газартай хамтарсан. Энэ маань 23 оны 10 сарын 31 энэ өдөр байгуулсан. Хуульд заасан журмыг шинэчилж боловсруулахтай холбоотойгоор 3 журмыг өнөөдөр боловсруулаад, батлаад Тагнуулын ерөнхий газрын даргатай хамтарч хоёрыг нь баталсан. Нэг нь дангаараа Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга баталж, өнөөдрийн байдлаар хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн, улсын бүртгэлийн албан ёсны сайт дээр байрлуулсан байгаа. Дэлгэцэд харагдаж байгаа энэ 3 журмыг бид нар боловсруулаад, нээлттэйгээр сайт дээрээ тавиад хэм хэмжээний актад бүртгүүлсэн байна. Нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах.

Хоёрт нь сонгогчдын нэрийн жагсаалт, үйлдэх үйл ажиллагаа, нэрийн жагсаалтаа танилцах, ашиглах журам.

Гуравт нь гадаадад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам гэсэн ийм 3 журмыг боловсруулаа.

Хоёрдугаарх нь хийгдсэн ажил 2012 оноос хойш энэ сонгогчдын бүртгэлийн тоног төхөөрөмж огт шинэчлэгдээгүй байсан. Үүнийг 23 онд бид нар шинэчилж 11 сард хүлээж авсан байгаа. Дэлгэцэд харагдаж байгаагаар ер нь улсын бүртгэлийн байгууллагын хэрэглэж байгаа тоног төхөөрөмж маань зөөврийн компьютер, хурууны хээ уншигч принтер, веб камер, бусад дагалдах хэрэгсэл буюу төрөл бүрийн холбогч залгуурууд, хамгаалалтын цүнх гэсэн ийм багцаас бүрддэг. Энэ багцыг 23 оны 11 дүгээр сард хүлээж авсан. Үүнээс хойш бид 2 сарын 2-ны өдөр хүртэл бүх бэлэн байдлыг, бүх компьютероо

шалгаад ажлын бэлэн байдалд өнөөдөр оруулсан байна.

Гуравдугаар ажлын хүрээнд программ, техник хангамжийн боловсруулалтын ажил ид хийгдээд явж байна. Энд ажлын хэсэг байгуулсан байгаа 24 онд. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний дата төв, Мэдээлэл холбооны сүлжээ гэсэн ийм газруудын оролцсон ажлын хэсэг байгуулж программ хангамжийн бодлогын даалгаврыг гүйцэтгэсэн. Дэлгэц дээр харагдаж байгаа 4 программ хангамжийг бид нар боловсруулах ёстой сонгогчдын мэдээлэлтэй танилцдаг.

Өөрөөр хэлбэл энэ 4 сарын 1-ний өдөр бид нар веб дээрээ сонгогчдын нэрийн жагсаалтын эхний хувилбарыг гаргана. Энэ программ ирц бүртгэлийн программ, гадаад улсад байгаа сонгогчдыг бүртгэх программ, яг сонгуулийн өдөр сонгогчийг таньж баталгаажуулах программ гэсэн ийм 4 программыг бид нар боловсруулах ёстой.

Үүнээс эхний программ ер нь боловсруулагдаад тестийн шатандаа явж байна. Ер нь хуульд нэлээн тодорхой өөрчлөлт орсон байгаа. Өөрөөр хэлбэл сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт цахим болон цаасан хэлбэртэй байна. Мөн нэгдсэн 1 сантай байна гэсэн нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор программ хангамж дээр нэлээн бас боловсруулалтын ажлууд бас хийгдэж байгаа гэдгийг бас үүндээ хэлмээр байна. Өөрөөр хэлбэл, яг онлайн байдлаар иргэдийг, сонгогчдыг бүртгэж түүнийгээ бас мэдээлж, эргэж тайлагнах ийм зориулалттай программ байгаа.

Дөрөвдүгээр ажлын хүрээнд энэ бол нэлээн яг сонгуулийн нэрийн жагсаалттай холбоотой энэ ажил байгаа. Сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө байгуулж, нутаг дэвсгэрийг зарлана гэж хуульд заасан байгаа.

Үүнтэй холбоотойгоор сум, дүүргийн 3 дугаар сарын 1-нд хэсгүүд байгуулах ёстой. Сум, дүүргийн ИТХ-ын тогтоолыг бид нар хүлээж авсан. Бүрэн хүлээгээд өнөөдрийн байдлаар авсан байна.

Тавдугаар ажлын хүрээнд сум, дүүргийн ИТХ-ын тогтоолыг шалгасан. Энэ шалгах ажил маань 3 сарын 3-наас 3 сарын 12-ны өдрүүдэд тогтоолыг нягталж шалгасан. Тогтоол дээр ийм асуудлууд байна. Шинэ суурьшлын бүсийг хаягтаа тусгаагүй. Өөрөөр хэлбэл, шинээр суурьшлын бүс, хаягууд нь огт тусгаадаагүй орж ирснээс дараа нь бас нэрийн жагсаалт гаргах үед энэ хаяг ороогүйн улмаас бас асуудал үүсэж магадгүй.

Хаяг орхигдсон буюу хаягийн бичвэр буруу байх. Тухайн хэсэгт хамааралгүй сонгогчийг тухайн хэсэгт хамааруулсан байдлаар энэ тогтоол гарсан. Ийм асуудлуудыг зөрчлийг тухай бүрд илрүүлээд тухай бүрд нь бас залруулж, засуулсан байгаа тогтоолууд дээр.

Мөн засаг захиргаа нэгжид байнга оршин суух хаягийн бүртгэлтэй сонгогчдын тоо 3000-аас давсан 11 хэсэг байна. Өөрөөр хэлбэл хуульд 3000 хүртэлх байгаа. Энэ 11 хэсэгтэй холбоотойгоор нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Сонгуулийн ерөнхий хороондоо мэдэгдсэн байгаа.

Ер нь ямар асуудал дээр яг энэ 3 сарын 3-наас 3 сарын 12-ны хооронд ажиллав гэхээр сум дүүргийн ИТХ-ын тогтоолд хаягийн нэршил буруу тусгасныг засах, тусгаадаагүй шинэ суурьшлын хаягийг нэмэх, шинээр ашиглалтад орж байгаа орон сууцын хорооллын мэдээллийг нэмэх, сонгогчдын тоо 3000-аас дээш байгаа эсэхийг хуваах гэсэн ийм асуудлаар Сонгуулийн ерөнхий хороотойгоо зөвшилцөөд явж байна.

Ялангуяа энэ шинээр Улаанбаатар хот гэхэд нэлээн олон

барилга байшин өнөөдрөөс хойш, 6 сарын 28 хүртэл ашиглалтад орж үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгээ авна. Энэ үед иргэд байнгын оршин суугаа хаягаа тухайн шинээр баригдсан орон сууц дээрээ бас шилжүүлж, шилжилт хөдөлгөөн зогсохоос өмнө шилжих ийм асуудал гарч магадгүй учраас тогтоолд бас үүнийгээ тусгах асуудлыг сум, дүүргийн ИТХ-тайгаа бас ярьж засуулах энэ зөрчлүүдийг арилгах энэ асуудлууд бас хийгдсэн энэ хугацаанд.

Тавдугаар асуудал. Тавдугаар хийгдсэн ажил маань. Сум дүүргийн ИТХ-ын тогтоолыг бид бүхэн шалгаад сонгогчдын бүртгэлийн программд шивж баталгаажуулдаг. Энэ шивж баталгаажуулах ажил маань хийгдсэн. Дэлгэцэд харагдаж байгаагаар орон нутаг болоод нийслэлийн 30 нэгжийн 339 тогтоолыг бид нар өнөөдөр хүлээж авсан. Үүн дээрээ хэсэг байгуулсан. Одоогийн байдлаар, урьдчилсан байдлаар 2188 хэсэг байна. Үүний 510 нь нийслэлд, 1678 нь орон нутагт. Урьдчилсан байдлаар ийм хэсэг маань гарч ирж байна.

Ингээд энэ хэсгүүддээ тухайлбал Архангай аймгаас 19 тогтоол ирсэн байна. Архангай аймаг 105 хэсэгтэй, сонгогчийн тоо 60911. Ийм байдлаар урьдчилсан байдлаар тооцооллуудыг гаргахад сонгогчийн тоо маань энэ жилийн хувьд 2 сая 233 мянга 737 байхаар урьдчилж гарсан энэ ажил. Энэ дээр бол үүнийг 3 сарын 17-ны өдрийн байдлаар бид нар яг ажлаа танилцуулж яг явцын байдлаа танилцуулж байгаа учраас 3 сарын 17-ны өдрийн байдлаар гаргасан. Үүн дээр нэмэгддэг. 6000 гаруй тухайн үед 18 нас хүрээд сонгогчийн насандаа хүрч байгаа иргэдийн тоо нэмэгддэг. 6-байгууллагатай холбоотойгоор бас энэ тодорхой өөрчлөлтүүд ордог. Цэргүүд байдаг юм уу, Дээд шүүхээс, Батлан хамгаалахын яамнаас, Цагдаагийн ерөнхий газраас гэх мэтчилэн газруудаас ирсэн мэдээллээр шинэчлэгддэг. Иргэний улсын



бүртгэлтэй холбоотойгоор бас мэдээлэл шинэчлэгддэг гэдгийг бас хэлмээр байна.

Өөрөөр хэлбэл, яг өнөөдрийн байдлаар та бүхэнд танилцуулахад дэлгэцэн дээр харагдаж байгаа ийм тогтоол 2188 хэсэгтэй, ийм тооны сонгогчтой байхаар программд орсон байна. Гарч байгаа асуудлыг та бүхэнд товч танилцуулъя.

Нэгдүгээрт нь яг өнөөдрийн байдлаар шилжилт хөдөлгөөний бүртгэлээ цаг хугацаандаа хийлгээгүй, шилжиж явсан боловч хуучин хаяг дээр бүртгэлтэй байгаа, нэг хаяг дээр олон бүртгэлтэй гэдэг юм бас тодорхой хэмжээнд байсаар байна. Хаягийн нэгдсэн нэг стандартгүйгээр нэг хороонд ижил дугаар олгогдсон ийм хаяг байна. Бүүр Улаанбаатар хотод.

Жишээ нь Хансвиллд 2 орцтой. Тэгэхээр 2 орцоо яг адилхан нэгээс авхуулаад дугаарлачихсан тоотой. Тэгэхээр бид нар орц гэдэг зүйл сонгогчдын нэрийн жагсаалтад байхгүй. Орц бол байхгүй. Хаягийн хувьд өөрөөр хэлбэл, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18.3-д маш тодорхой заасан байдаг. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаяг гэдэг нь аймаг, сум, нийслэл, дүүргийн нэр, баг, хорооны нэр, дугаар, хороолол, гудамж, байр, хаалга гэж байдаг. Тэгэхээр магадгүй тухайн байраар нь ингээд үзэхлээр тухайн байрны 1 тоот гэхээр хоёр 1 тооттой, 2 тусдаа айл. Энэ маань программаар нэг болж гаргах харагдах ийм зүйл бас гарч ирж байна. Тэгэхээр миний энэ байранд бас өөр хүмүүс бас байна гэдэг ийм асуудал гарч болзошгүй харагдаж байна.

Өөрөөр хэлбэл тухайн байрыг яг нэг стандартгүйгээр, дараалалгүйгээр орц болгоноо 1-ээс дугаарлачихсантай холбоотой ийм асуудал гарч байна. Нэг хаяг дээр бичвэрийн зөрүү үүсдэг бичвэрийн хувьд. Харьцангуй агуулгын хувьдалдаагүй.

Гэхдээ Хандгайт, Хандгайтын ч гэдэг юм уу, тухайн гудамжийг арай өөр хэлбэрээр, арай өөр үгээр бас бичих, зайтай бичих ч гэдэг юм уу программчлахад нэлээн бас төвөгтэй байдлаар хаягийн бичвэр дээр зөрүү үүсэж байна.

Мөн нэлээн сонгууль болгон дээр бас гардаг. Өнөөдрийн энэ бас мэдээлэл дээр би онцгойлон бас энийг хэлж байгаа нь гэр хорооллын нэг хаягт олон өрх байдаг. Өөрөөр хэлбэл би маш тодорхой энэ судалгаануудыг гаргасан байгаа. Бас та бүхэнд хүргүүлъя. Энэ дээр хашаагаа 2-3 хуваачихсан маш олон тооны өрхүүд байдаг. Яг амьдрал дээр оршин суугаа хаягийнх нь тоот нь нэг. Дотроо 6-7 өрх, бүүр 8 өрх, 9 өрх ч байхаар. Тэгэхээр тухайн тоот дээр маш олон иргэд байна гэж бас сонгуулийн нэрийн хэсэг нь харагдахаар харагдаж байгаа.

Мөн хөдөө орон нутаг дээр энэ багийн иргэд нэг хаяг дээр байгаа мэт харагддаг. Хөдөө гэдэг. Өөрөөр хэлбэл, яг хотын иргэд бол аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж байр гээд явдаг бол орон нутаг дээр аймаг, сум, баг. Багаас цаашаа задрахгүй ийм зохион байгуулалт хөдөө гээд. Тэгэхээр багийн иргэд нэг дор харагддаг. Одоо бид нар программаар харуулахлаар багийн иргэд бол тухайн баг дээр хэдэн хүн байна тэр бол нэг хаяг дээр байгаа мэтээр ингэж харагддаг. Энэ бас ойлголтын зөрүү болж магадгүй гээд та бүхэнд бас танилцуулж байгаа юм.

Дараагийнх нь би үүнийг өшөө тодорхой бас энэ энд мэдээлэл өгмөөр байна. Нэг хаяг буюу нэг тоот дээр 10-аас дээш сонгогч бүртгэгдсэн, 10-аас дээш 3226 хаягт 40082 иргэн байна. 42082 иргэн байна. Үүнийг жишээ болгоод дэлгэцэд би харуулж байгаа юм.

Ингээд БЗД-ийн 31 дүгээр хороо, Монос 1 дүгээр гудамж энэ “Зөв амьдрах ухаан” ТББ-ын энэ хаяг дээр 79 иргэн байна. СХД-ийн 6 дугаар хороо ХМК байгаа энэ хаяг дээр 231 иргэн байна. Энэ

хуучнаар “Амьдрах ухаан” сургалтын төв. Энэ дэлгэц дээр гарч байгаагаар нэлээн хэд хэдэн халамж, асрамжийн ийм зориулалтын байрнууд байгаад байгаа юм.

Нөгөө нэг хэсэг нь миний түрүүний хэлдэг нэг тоот дээр маш олон өрх амьдарч байгаа ийм жишээ. Би дэлгэц дээр маш бодитойгоор бас ингэж харуулж байгаа. БЗД-ийн 13 дугаар хороо, дүүргийн 11-ийн 531 тоот хаягт 32 иргэн байна. Миний түрүүний хэлсэн шалтгаан нь нэг тоот дээр маш олон иргэн байгаа. СХД-ийн 1 дүгээр хороо Толгойт дээр бас энэ асуудал яригдаж байна. Ховд аймагт бас байна. Ховд аймагт энэ асрамжийн байр байсан. Энэ дээр 16 иргэн байна.

Мөн энэ Дархан, Сэлэнгийг би жишээ болгож дэлгэц дээр харуулж байгаа юм. Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр баг дээр нөгөө хөдөө хаяг дээр хөдөө гэж байгаа учраас олон иргэд харагдах. Сэлэнгэ аймгийн Сайхан сумд бас ийм хөдөө гэж байгаа учраас олон иргэд нэг хаяг дээр байгаа харагдахаар байна.

Мөн өмнөх бас сонгуулиудын үед бас гарч байсан. Энэ дэлгэц дээр Хүний мэдээлэл хамгаалах хуулиар энэ дэлгэц дээр бол би регистрийн дугаарыг, овог, нэрийг бичээгүй юм. Дэлгэц дээр харагдаж байгаа дээр.

Нарийн мэдээлэл шаардлагатай бол энэ Бүртгэл, хяналтын дэд хороонд бас хүргүүлье. Энэ дээр овог, ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр нь ижил нэг хаяг дээр байгаа ихэр хүмүүс. Ихэр мөртөө адилхан нэртэй. Тэгэхээр регистрийн дугаар нь яг адилхан. Сүүлийн хоёрхон орон л зөрүүтэй. Ийм байх 6 иргэн байна. СХД-т, Баянзүрх-д, Хөвсгөл аймагт.

Мөн овог, ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр ижил өөр хаяг дээр байгаа ихрүүд мөн ижил нэртэй ихэр. Гэхдээ өөр хаяг дээр

байгаа. Эндээс юу харагдаж байна вэ? Цаашид үл ойлголцох, ялангуяа ойлголт дээр эрсдэл гарч магадгүй гэж би үүнийг бас танилцуулж байгаа юм. Сонгогчдын нэрийн жагсаалт дээр бүртгэхэд яг адилхан эцгийн нэртэй, яг адилхан нэртэй, төрсөн он, сар, өдөр нь яг адилхан ийм хүн магадгүй хувилагдчихсан байхаар харагдаж болзошгүй байна. Буруу ойлголт авч болохоор. Яг тухайн хаяг дээрээ бас яг адилхан. Нэг хүнийг яг л хоёр тавьчихсан. Төрсөн он, сар, өдөр нь хүртэл ижил учраас.

Мөн өөр хаяг дээр амьдарч байгаа ийм хүмүүс байна. Яг адилхан нэртэй ихрүүд. Тэгэхээр энэ бас яг нэг хүнийг бас хоёр хувилаад тавьчихсан мэт харагдах ийм эрсдэл гарч байна.

Мөн ийм байдлаар бид нар бас асуудлуудыг шүүж үзсэн. Энэ мэдээж хууль зөрчөөгүй, ямар нэгэн журам зөрчөөгүй. Энэ бол албан ёсны сонгогч өөрсдөө мөн.

Эцгийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар нь ижил гэхдээ ихэр биш ийм хүмүүс бас нэг хаяг дээр амьдарч байгаа ийм хүмүүс байгаа. Яг нэрийн жагсаалт дээр харахлаар яг л адилхан овог, эцгийн нэр, эх, өөрийн нэр нь адилхан харагдана, төрсөн он нь адилхан харагдана, хаяг нь адилхан харагдахаар ийм бас жишээнүүд байна гэдгийг бас энд мэдээлж байгаа юм.

Миний хамгийн сүүлийн слайд. Ер нь бид нар яг хаана явна вэ гээд энэ слайд, дэлгэц дээр харагдаж байгаа юм. Бид нар эхний нягтлан шалгаад ер нь сонгогчдын нэрийн жагсаалт дээр сонгогчийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг байдаг.

Ийм бүхий хаягийг өнөөдөр 3 сарын 19-ний байдлаар бид нар эхний хувилбараар яг гаргах буюу хэсэг оноох үйл ажиллагаа яг энэ цаг мөчид бас хийгдэж байна. Ингээд 4 сарын 1-ний өдөр бид өөрийн цахим хуудаснаас

сонгуулийн энэ сонгогчдын нэрийн жагсаалтын эхний хувилбарыг 4 сарын 1-ний өдөр байрлуулна.

Дараа нь товчхон хэлчихье. Дараа бид нар 5 сарын 1-ний өдөр 6-н байгууллагатай холбоотой өөрчлөлтийг хийнэ. 6-н байгууллагатай холбоотой гэдэг маань Дээд шүүх, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаа, Батлан хамгаалах яам, Иргэн харьяатын газар ч гэдэг юм уу ийм газруудтайгаа мэдээлэл солилцоод энэ сонгогчдын нэрийн жагсаалт өөрчлөлт оруулдаг.

Дараа нь хамгийн эхний хувилбар ингээд 5 сарын 1-нээс хойш хэвлэгддэг. Энд нягтлан шалгах үйл ажиллагаа хийгддэг. Үүний дараа итгэмжлэгдсэн ажилтанд томилогдоно. Манайтай гэрээ хийж ажилладаг. Итгэмжлэгдсэн ажилтнаар дамжуулаад иргэд сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах боломжоор хангагддаг. Мөн энэ явцад сонгогч шилжих, гомдлыг шийдвэрлэх, танилцуулах үйл ажиллагаанууд явагддаг. Ингээд сонгууль болохоос 3 хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалт эцсийн байдлаар эцэслэгдэж бас гардаг. Ингээд энэ жилийн ийм үйл ажиллагаанууд цаашидаа хийгдэх нь.

Эцэст нь дүгнээд хэлэхэд ер нь Монгол Улсын Их Хурлын 24 оны сонгуулийн тухай хууль дээр хэд хэдэн онцлог заалт орсон нь нэгдүгээрх нь энэ хуульд заасан 20.21 дээр байгаа Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, ТББ-ын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцаж болно гэдэг ийм заалт орсон.

Ийм учраас энэ танилцуулах үйл ажиллагаанд улсын бүртгэлийн байгууллага бэлэн байгаа. Энэ зохион байгуулалтад ороод бид нар үүнийг танилцуулахад яг энэ саяын гарч байгаа асуудлууд, дээрээс нь хэсэг оноолтууд хэрхэн яаж хэнээс ирдэг юм? Үүнийгээ яаж хэсэг оноодог юм, иргэний улсын

бүртгэлийн мэдээллийн сан дээр үндэслээд сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх үйл ажиллагаа яг яаж явагддаг талаар танилцуулахад бас бэлэн байгаа гэдгийг энд мэдээлж байна. Мэдээлэл дууслаа.

**Ж.Батсуурь:** Дэлгэрсайхан даргад баярлалаа.

Сонгуулийн хорооны ерөнхий хорооны мэдээлэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын танилцуулгатай, мэдээлэлтэй холбоотой асуух асуух асуулттай Дэд хорооны гишүүн байна уу? Ганболд гишүүн, дараа нь би байгаа.

**Г.Ганболд:** Манай Дэд хорооны үндсэн зорилго бол ерөөсөө энэ сонгуулийн байгууллагуудтай хамтарч сонгуулийг хүлээн зөвшөөрүүлэхэд л хамаг анхаарлаа хандуулах ёстой л доо. Сүүлийн үед дэлхий нийтээр энэ сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх ийм чиг хандлага асар их болж байгаа. Үүнээс л урьдчилан сэргийлэхийн тулд л энэ Дэд хороо байгуулагдаж ажиллаж байгаа.

Тэгэхээр зэрэг үүний төлөө сонгуулийн байгууллага, улсын бүртгэлийн байгууллагууд урьдчилж энэ зүйлүүдээ маш сайн ярих ёстой л доо. Ер нь бол миний хувьд би яг нэг асуулт.

**Ж.Батсуурь:** Уучлаарай. Ер нь бид хэд чинь бүх, би ч гэсэн бас Байнгын хороон дээр байж байгаа. Гэхдээ хэдүүлээ бас бүх л ажил чухал юм чинь би бас асуултыг үргэлжлүүлээд явчихъя гэж бодож байгаа юм.

Энэ цаг мөчид та бидний хамтын ажиллагаа саяын Ганболд даргын хэлсэн шиг сонгуулийн итгэл үнэмшилтэй өгөх, үр дүнг нь бүх хүн, оролцогч намууд, бүх нэр дэвшигчид хүлээн зөвшөөрөх. Хаашаа ч гарцгүй энэ бодит мэдээллийг л өгөх нь чухал гэдэг. Тэр 92 оны Үндсэн хуулиас хойш байдаг хүн чинь 8 удаагийн сонгууль өгсөн. Янз бүрийн л хэлбэрүүдээр янз бүрийн л системүүдээр, гараар, янз

бүрийн л үлгэр домог шиг юмнууд хүртэл байдаг.

Тэгээд 21 дүгээр зуун одоо технологи шинэчлэгдэж байна. Тэр үед ажиллаж байсан Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн газрын бааз суурь энэ тэр харьцуулахын аргагүй болчихсон байна. Та бүхэн ч гэсэн бас олон зүйлийг хийсэн байна.

Мөн өмнө нь Улсын Их Хурал болон Байнгын хороо улсын төсөв дээр та бүхнийг энэ хийх ажлын чинь боломжийг хангаж мөнгө төгрөгийг нь хангалттай хэмжээнд тавьж өгсөн, орон тоог нь өөрсдийн чинь хүссэн хэлбэрээр баталж өгсөн, мөн гол нь цалин цагаан нэмэгдэл гээд төрөөс хийх зүйлүүд байвал бас хангалттай хийсэн гэж ингэж үзэж байгаа юм.

Одоо хэдүүлээ энэ хийх нэг үүрэг, ард түмний өмнө үүнийгээ. Ганболд гишүүний юуг үргэлжлүүлбэ.

**Г.Ганболд:** Тийм учраас сонгуулийн дүн хүлээн зөвшөөрөхгүй байх асуудал бол хэд хэдэн зүйл дээр л байгаа юм. Сонгуулийн ерөнхий хорооны хар машинтай холбоотой асуудал, сүлжээгүй байгаа алслагдсан багуудын зөөвөрлөж сүлжээн дээр аваачиж дүн гардаг асуудлууд хамгийн их хэл ам дагуулдаг юм орон нутагт. Тэр дундаа цөөн саналаар 100, 200 хүний саналаар ялж, ялагдсан хүмүүсийн хооронд бол тэр дээр маш их хардалт явдаг юм л даа. Таны энэ мэдээллээс харахад 223 цэг одоогоор үүрэн холбооны ч юм уу ямар нэгэн сүлжээ байхгүй байна. 223 хэсгийн хорооны хар машиныг зөөвөрлөх нь гэж ойлгож байна тийм ээ? Одоо бол бас ч гэж харьцангуй үүрэн холбооны хөгжил өндөр болчихлоо шүү дээ. Старлинкийн сүлжээ орчихлоо тийм ээ? Үүнтэй холбоотой нэг Старлинкийн антен 1 сая 500 мянга орчим төгрөг гэж ойлгож байгаа шүү дээ. Энэ дүнгээр бодох юм бол 300 гаран сая төгрөг л юм байна. Энэ асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо өөрийн төсөв дээр багтаагаад шийдэх

боломж байгаа юу? Боломж байхгүй бол бас Дэд хороогоор дамжуулаад энэ саналыг шийдчих юм бол 300 сая төгрөгөөс, дараа нь яах вэ ашигчлахаад тухайн багт өгчхөж болно шүү дээ энэ чинь Хэрэг эрхлэх газрын шугамаар шийдүүлээд. Сонгуулийн үед ашигчлахаад дараа нь тэр багийн иргэд нь өөрсдөө Старлинкээ ашиглаад явах ийм ийм боломж байна уу гэдгийг би танаас асуух гээд байгаа юм. Энэ бас нэг гол хэл ам дагуулдаг зүйл.

Хоёрт нь энэ 2243 ширхэг санал тоолох төхөөрөмжийг ашиглалтын хугацаа нь 3 жилээр сунгачихсан гэх юм. Хэн сунгадаг юм үүнийг? Энэ өөрөө яг хугацаа нь дуусчхаад байхад сунгаад байна уу? Үүнийг нь баталгаажуулдаг байгууллага нь юу байна? Үүнийг бас жаахан албан ёсны юм явахгүй бол хугацаа нь дуусчихсан юмыг 3 жилээр сунгаад дахиж ашиглах гээд байгаа юм шиг ийм ойлголт гарах вий. Үүнээсээ болоод бас л нөгөө сонгуулийн дүнг эсэргүүцсэн ийм асуудал руу орох вий гэдэг ийм болгоомжлол байна. Бас мэдээ дамжуулалтад нөлөөлөх нөлөөлөл бас байх вий. Үүнийг асууя.

Дэлгэрсайхан даргаас хаягжуулалтын асуудал чухал л даа. Таны саяын яг гарч байгаа асуудлуудыг бүгдийг нь ойлгож байна. Маш чухал асуудал л даа. Бид нар араас нь хөөж хэл ам гарсны дараа араас нь хөөж тайлбарлавал хэн ч үүнийг ойлгодоггүй. Тэгээд үүнийг сонгууль болохоос өмнө урьдчилаад.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** 1 минут сунгачихъя. Энэ чинь гол нь асуулт дутуу л гэх ёстой байх тийм ээ?

**Г.Ганболд:** Тийм учраас энэ хаягжуулалтын асуудлыг сэрэмжлүүлэх зорилгоор таны маш тодорхой энэ кэйсүүдээ сонгууль болохоос өмнө урьдчилаад хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр ийм байна, үүнийгээ өөрчилмөөр байна, энийг яах вэ гэдгээ нийгэмд хоногштол нь ингэж явуулж

байж дараа нь тайлбарлах юм бол үр дүнтэй. Үүнийг зөвхөн бид нарт ярьж байгаад сүүлд нь их гомдол гарсны дараа мянга яриад ойлгохгүй. Энэ тал дээр бас нэг онцгой анхаарал хандуулж ажиллаач. Энэ дээр та нар ямархуу ажил хийхээр төлөвлөж байна вэ? Энэ гарсан нэрсийн жагсаалтууд ер нь өөрчлөлт хэр орох вэ энэ яг тоогоор гарсан дээр? Би уг нь бас хариултаа сонсмоор байна. Бас яг нэг асуулт.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** Хариултыг нь орж ирсэн хойно нь явчихъя тэгэх үү зарчмын хувьд. Манай Дэд хороо чинь гуравхан хүнтэй. Тэгэхдээ бид нарын үр дүн нь бид нарт хамаарах учраас. Би ч гэсэн тэнд үг авчихсан. Гаалийн албан татвар, орон нутаг гээд байж байгаа. Тэгэхдээ одоо нөхцөл байдлууд ингэж таарч байна. Ганболд гишүүний асуултыг Ганболд гишүүнийг орж ирэнгүүт нь хариултыг нь өгүүлээд, тэгээд хэдүүлээ тодруулаад явъя.

Ер нь асууж байгаа асуулт, хэлж байгаа саналууд бол хэдүүлээ бүхэлдээ энэ сонгуулийг бүх оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх тал дээр л анхаарах учраас жижиг гэлтгүй асуултуудыг бас асуугаад явчихъя гэж ингэж бодож байгаа юм.

Нэгдүгээр асуултад хэсгийн хороонд нийт хэдэн хүн ажиллахаар тогтоод байгаа вэ? Дээд, доод хязгаар гэж байгаа юу гэсэн ийм зүйл байгаа. Нэг хэсгийн хороог хэдээс хэд гэж хязгаарлаж байгаа вэ? Хэсгийн хороонд ажиллах хүмүүсийг заавал сертификаттай байна гэсэн зүйл ярьдаг санагдаад байгаа юм.

Тэгэхлээр энэ сертификаттай нэгтгэвэл хэдэн хүн байна вэ? Сертификатгүй хэдэн хүн байна вэ? Энэ сургалтыг хэдэн сарын хэдний дотор гэхэд хийж дуусгах вэ гэсэн? Нийтдээ энэ төхөөрөмжүүд бэлэн болоод байршихад бэлэн болчихлоор энэ төхөөрөмжийн туршилт гэж хийх үү? 100 хувь хийх үү, тодорхой ийм түүвэр

байдлаар хийх үү гэж? Түрүүнд хэлсэн гэхдээ тодруулаад асуусан. Сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэдний дотор, ямар хэлбэрээр өгөх вэ? Файл хэлбэрээр өгөх үү, си ди /CD/ хэлбэрээр өгөх үү, сүлжээ, и-мэйл, бусад байдлуудаар өгөх үү гэж? Сонгуультай холбоотой Сонгуулийн ерөнхий хороо, Иргэний бүртгэлээс гарч байгаа журмууд нууцад хамаарах зүйл бий юу? Байхгүй бол бүгд сайтууддаа цаг тухайдаа орж чадах уу гэсэн ийм асуултууд байна.

Ижил нэртэй болон энэ хүмүүсийн нөхцөл байдлыг яах зорилгоор энэ дээр тайлбарласангүй. Ер нь авъя гэвэл авч болно гэсэн зүйлүүд байж байна. Үүнийг бас ер нь асуулт гэхээр ээс илүү авъя гэж ингэж бодож байна.

Дараагийн асуулт, хуучин Байнгын хороон дээр яригдаж байсан сүлжээгүй газруудаас сүлжээтэй газар руугаа зөвөөрлөнө гэж. Тэгэхлээр энэ сая Ганболд ч ярьж байна. Старлинкийн үйлчилгээ гарч ирэх энэ нөхцөл байдлыг хангачих юм бол миний өмнө байнга асуугаад байдаг банкны гүйлгээ шиг болж чадахгүй уу?

Жишээлэх юм бол сонгогчдын тоо бүгдээрээ сүлжээнд байж байдаг. Тэгээд л Ховд аймагт, Говь-Алтай аймагт өгөнгүүт нөгөөдөх нь шууд цаг шиг нэмэгдээд нэгдсэн үндсэндээ. Хуучин бол нэгдсэн систем гэж яриад байгаа мөртөө энэ бас нэгдсэн систем биш юм гэнэт пүл пүл гээд орж ирдэг шүү дээ. Тэгэнгүүт тэн дээр хүмүүс хардаад байдаг шүү дээ. Тийм болохлоор одоо энэ Старлинкийн үйлчилгээг хийгээд бүх хэсэг, нэгжүүд сүлжээнд холбогдох юм бол энэ чинь өөрөө яг банкны сая төгрөг байж байгаад “Хаан” банк ч юм уу, “Голомт” банк ч юм уу 50000 төгрөгийн гүйлгээ хийнгүүт 950 болдог шиг ийм гүйлгээ хийгдэх үү гэсэн ийм асуултуудыг асууя. Тэгээд дараагийн байдлаар тайлбараа авъя.

**П.Дэлгэрнарэн:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Ер нь

хэсгийн хорооны бүрэлдэхүүн хуульд зааснаар 5-7 гэж байгаа. Ингээд нийтдээ бол 2188 одоогоор 3000-уудыг нэмэх юм бол бид нар бараг 2199, 2220, 200 руу ингээж дөхөж очихоор ийм тооцоо урьдчилсан тооцоо байна. Ингээд бүх шатны сум, аймаг, нийслэл, дүүрэг, хэсгийн хороодуудтайгаа нийлээд энэ жил бүхэлдээ бол 25000 орчим төрийн албан хаагчид энэ бүх шатны сонгуулийн байгууллагуудад ажиллахаар байгаа. Энэ бол урьд нь 18000 орчим төрийн албан хаагч ажиллаж байсан. Энэ жилийнх бол хэсгийн хороодуудын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор бол төрийн алба, нийт ажиллах төрийн албан хаагчдын тоо нэмэгдэнэ.

Одоогийн байдлаар бол сертификатаа манай нэгдсэн санд бүртгэлтэй сонгуулийн байгууллагад ажиллаад өмнө нь ажиллаад сертификат авсан төрийн албан хаагчид бол 32000 төрийн албан хаагчдын сан байна бид нарт.

Гэхдээ энэ улсууд маань бас ажлын боломж, өөрсдийн бас хүсэл, өөрсдийн сайн дурын санаа бодлоороо ажилладаг учраас, илэрхийлж ажилладаг учраас эд нарыг бүгдийг нь ажиллана гэж бол тооцож болохгүй. Шинээр хүмүүс, бас бүр шинээр бүртгэгдэж, сургалтад хамрагдаж сертификат аваад ажиллана. Хуучин байгаа улсуудын маань сертификатыг бол хүчин төгөлдөрт тооцно. Томилогдсон бүх шатны хэсгийн хороодод томилогдсон ажилтнуудыг бол танхимаараа мөн бид нар дахин нарийвчилсан давтан сургалтад хамруулж байж ингээж сонгуулийн байгууллагууддаа ажиллуулах юм.

Техник хэрэгслийг бол 100 хувийг туршина. Энэ бол хууль дээр заалт аваад санал хураалт болохоос 3 хоногийн өмнө бол улсын хэмжээнд шалган турших ажиллагааг бүгдийг нь туршиж үзнэ. Бүх хэсгийн хороодууд бол санал тоолох төхөөрөмжүүд маань бүгд хүргэгдсэн байх үе. Үүнийг сүлжээнд холбоод, үүний

үйл ажиллагааг бүгдийг нь шалган туршина. Энэ шалган турших явцад бол бүх газруудад ажиглагчид байж ажигладаг. Бүх сонгуульд оролцож байгаа намууд болон олон нийтийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагууд үүнийг бол оролцож ингээж ажигладаг.

Батлагдаж байгаа журам одоогоор бид нар бол ер нь ихэнх журмуудаа баталж байгаа.

Яагаад гэвэл энэ сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой нэгдсэн гарын авлага, товхимол хэвлэх гээд бид нар бас энэ юмнуудаа бас жаахан хуулийнхаа хугацаанд багтаагаад жаахан шахуухан, хурдан эрт хэвлэхээр ингээж ажиллаж байна. Бид нар бол олон газрууд хамтарсан журмууд гаргадаг. Энэ журмууд дотор бол нууцад хамааралтай зүйл байхгүй. Гол нь энэ журмууд чинь нийтээр дагаж мөрддөг учраас Хууль зүй, дотоод хэргийн яаманд очиж бүртгэгддэг, өөрчлөлт ордог. Тэр өөрчлөлтүүдээ л бид нар хурдан хийлгээд авбал үүнийг бид нар товхимол болгоод хэвлээд, маш ойрын хугацаанд ингээд гаргаад явуулчих боломж байна.

**Ж.Батсуурь:** Дэлгэрсайхан дарга.

**Д.Дэлгэрсайхан:** Улсын бүртгэл Дэлгэрсайхан, Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг өгөхтэй холбоотой заалт хуульд маш тодорхой заасан байгаа. Өөрөөр хэлбэл хуулийн 20.15 дээр улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу, хүсэлтийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 удаа санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө, санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус 2 удаа цахим хэлбэрээр олгохоор ийм хуульд тухайлсан заалт байгаа учраас бас хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.

Өөрөөр хэлбэл 2 удаа дээрх этгээдүүдэд сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хэлбэрээр олгох нь. Энийг цахим хэлбэрээр. Энэ дээр ямар нэгэн өмнө бас яригдаж байсан та бас санаж байгаа байх Их Хурал дээр хуулийн нэмэлт, өөрчлөлт орж байх үед бас файлийг хаасан, блоклосон ч байдаг юм уу, тэр файл нь өөрөө эвдрэлтэй байсан гэдэг ийм асуудал, өмнө нь зөвхөн тухайн файл хуулагдахаас хамгаалсан байсан. Одоо бол мэдээж энэ цахимын хуулиуд гарсантай холбоотойгоор хүний мэдээлэл хамгаалах байдаг юм уу үүнтэй холбоотой хуулийн заалт нь хэрвээ энэ мэдээллийг цаашид хүний мэдээллийг задруулсан тохиолдолд хуулийнх нь заалт байж байгаа учраас бид нар үүнийг ямар нэгэн кодгүйгээр шууд олгохоор ийм зохицуулалттайгаар бид нар ажиллаж байна. Нэг.

Хоёрт нь энэ журамтай холбоотойгоор бид нар хэм хэмжээний актад 3 журмаа бүртгүүлчихсэн байгаа. Энэ дээр нууцын асуудал байхгүй. Яг өнөөдөр бид нар [birtgel.gov.mn](http://birtgel.gov.mn) гэсэн сайтдаа энэ журмуудыг байрлуулсан байгаа 3 журмаа.

Дараагийнхны нэгдсэн системтэй холбоотойгоор. Үнэхээр энэ хуульд бас нэмэлт, өөрчлөлт орохдоо энэ Улсын бүртгэлийн нэгдсэн сан энэ хэсгүүдтэй уялдаж ажиллахтай холбоотойгоор маш тодорхой заалт орсон. Нэгдсэн нэг сантай байна. Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй байна гээд. Яг таны хэлж байгаачлан бид нар программ хангамж техникийн шийдлүүдийг хийж байгаа.

Өөрөөр хэлбэл яг Дэлгэрсайхан Архангай аймгийн Цэнхэр сумаас ирц бүртгэлийн программ дээр өөрийгөө оруулсан тохиолдолд шууд төв сервер рүү мэдээллээ шийдэхээр. Энэ дээр бид нар өнгөрсөн хугацаанд нэлээн ажилласан. 1 сарын 15-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнарнд Улсын бүртгэлийн ерөнхий

газрын даргаас дэмжлэг хүсэх тухай ийм бичиг явуулсан юм. Энэ бичгийн заалт нь юу вэ гэхээр ерөөсөө л хэсгийн хороодуудыг сүлжээнд холбохтой холбоотойгоор. Ингээд улсын бүртгэлийн байгууллага өөрөө өнгөрсөн оноос хойш бүх судалгаа, тооцоонуудыг хийсэн юм. Өөрөөр хэлбэл ямар хэсгийн хороодуудаар, хэсгийн хороодуудын байр, ажлаас авхуулаад хаана холбогдох юм, ямар сүлжээ холбогдох юм. Энэ дээрээс VPN сүлжээ холбохтой холбоотойгоор Тагнуулын ерөнхий газраас энэ сүлжээ үүсгэх, ...-гүй холболт ашиглахгүй байхыг зөвлөмжүүд ашиглах талаар зөвлөмжүүд ирсэн юм.

Ингээд 2 сарын 24-ний өдөр Сонгуулийн ерөнхий хорооны дүгнэлт, дэд ажлын хэсгийн санал, дүгнэлт бас гарсан байгаа юм. Энэ бол Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн саналыг шийдвэрлэхээр Тагнуулын ерөнхий газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд бичиг хүргүүлээд зөвлөмж ирсний дагуу үүнийг авч хэлэлцээд энэ VPN сүлжээг энийг холбох нь зүйтэй юм байна гэдэг ийм санал, дүгнэлт гарсан. Үүнийхээ дагуу бүх судалгааг энэ дээр хийсэн юм байгаа юм. Бүх хэсгүүдээрээ, холбогдож гарах зардлаараа. Энэ бол яг улсын бүртгэлийн байгууллага байдаг юм уу шууд хамаарагдах зардал бас биш байсан. Ийм учраас маргааш Төсвийн байнгын хороогоор бас үүний зардалтай холбоотой асуудал бас орж байгаа. Та бүхнийг бас дэмжиж өгөхийг бас хүсэж байна.

Өөрөөр хэлбэл яг хэсгийн хороодыг шууд онлайн сүлжээнд холбох ийм сүлжээний.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** Микрофоныг нь нэмээд өгчих. Годруулаарай Старлинк, нөгөө алслагдсаныг.

**Д.Дэлгэрсайхан:** Тэгэхээр энэ дээр Старлинк гэхээр биш. Өөр хэлбэрээр шийдэхээр энэ Тагнуул руу хүсэлт гаргаад, зөвлөмж явуулсан юм. Тэгэхээр

энэ дээр үндсэндээ хөдөлгөөнт сүлжээ зохион байгуулахаар энэ судалгааг хийгээд энэ маань Тагнуулын ерөнхий газраас бас VPN энэ сүлжээг хийж болно гэж дэмжигдсэн юм байгаа юм. Зөвшөөрсөн гэсэн үг. Зөвшөөрөөгүй, хүсэлт гаргасан гэсэн шүү дээ. Хүсэлт гаргаад, би хүсэлт Дэлгэрнаран дарга руу, Дэлгэрнаран дарга цаашаагаа Тагнуулаас зөвлөмжөө аваад, Тагнуулын ерөнхий газар зөвшөөрчхөөд байгаа юм. Тагнуулын ерөнхий газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зөвлөмжийг бид нарт ирүүлээд, энэ зөвлөмжөөрөө та нар хийхэд болно гэдэг асуудлаа техникийн шийдлүүдээ бид нар гаргачихсан байгаа.

Тэгэхээр энэ шийдэл зөвхөн Улсын Их Хурал энд биш энэ зардал маань орон нутаг болоод цаашидаа хэрэглэгдэх буюу миний түрүүний дэлгэц дээр харуулсан 7 төрлийн багц дотор энэ хэрэг.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** Саяын асуудал шийдэгдэхэд таны энэ ингэж байна шүү дээ. Гарч буй асуудал гээд байна шүү дээ. Гарч буй асуудал гээд асуудлуудыг гаргаж ирж тавьсан. Саяын энэ сүлжээний асуудал хөрөнгө мөнгө нь шийдэгдээд, энэ техникийн шинэчлэл хийгдэхэд энэ тавьж байгаа асуудлын хэдэн хувь нь шийдэгдэх вэ? Жишээлэх юм бол хаягийн давхардал ч байдаг юм уу.

**Д.Дэлгэрсайхан:** Энэ хаягийн асуудал арай өөр, хоёр өөр тусдаа л асуудал юм байгаад байгаа юм. Түрүүн таны ярьдаг тухайн сонгогч, ер нь бид нар яг энэ системийг хийсэн тохиолдолд онлайн сонгуулийн яг л түвшинд бид нар очлоо л гэсэн үг. Тэгэхээр энэ шийдэл бол иүүд хаягтай бас холбоогүй байгаа. Хаяг дээр тухайн иргэдээс бас хамаарах ийм асуудлууд байгаад байгаа юм. Би түрүүн Ганболд гишүүний асуусан тэр асуулт дээр бас ярих гээд байна л даа. Энэ яг хаягтай холбоотойгоор нэлээн сурталчлах шаардлагатай байна, нэлээн хэдэн ажлууд бас хийх шаардлага үүсээд

байгаа юм хаяг дээр. Бусад асуудлын хүрээнд 100 хувийг шийдэгдэнэ. Төсөв, зардал нь шийдэгдвэл.

**Ж.Батсуурь:** Энэ гарч буй асуудлын 3 дугаар слайд, энэ сүүлийн слайд дээр овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он сар ижил нэг цэгт оршин суудаг ихэр гээд тоо тавингуут энэ арынх нь давхардлын тоо юм уу? 19, 31, 23 гэж энэ юу юм? Энэ регистрийн сүүлийн дугаар юм уу? Ийм зөрчилтэй нийт хэдэн хүн байгаад байгаа юм одоо?

**Д.Дэлгэрсайхан:** Асуултад хариулъя. Энэ бол зөрчил биш юм байгаа юм. Би тайлбар дээрээ цаашид үл ойлголцол гарч, эрсдэл магадгүй л гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл яг ихэр мөртөө яг ижилхэн нэр өгчихсөн л ийм тохиолдлууд байгаад байгаа юм л даа. Тэгэхээр ихэр байж байгаа учраас регистрийн дугаарын эхний 2 үсэг нь адилхан, төрсөн он, сар, өдөр адилхан.

Өөрөөр хэлбэл сүүлийн 2 оронг би яг энэ дээр, дэлгэц дээр харуулсан юм. Энэ бодит жишээ нь энэ дээр байж байгаа юм. Би танд бас хүргүүлъя. Яг бодит мэдээлэл нь. Дэлгэц дээр би зөвхөн бас тухайн хүний мэдээллийг бас хамгаалах үүднээс товч гаргаад байгаа юм. Сүүлийн 2 орон үндсэндээ регистрийн дугаарын сүүлийн 2 оронгоор л ялгагдаж байгаа юм. Магадгүй энэ нь сонгогчдын нэрийн жагсаалт дээр нэг хүнийг 2 хувилчихсан мэт харагдаж магадгүй ийм ойлголт, үл ойлголцол гарч магадгүй гэдгээр би энэ мэдээллийг өгсөн юм байгаа юм.

**Ж.Батсуурь:** Тийм, ойлгож байна. Ийм давхардалтай ч гэдэг юм уу, ийм улсын хэмжээнд ойролцоогоор хэдэн хүн байна вэ л гэж асуугаад байгаа юм? Ихэр ингээд өөрийн чинь хэлээд байгаа нэг хувилбарууд байна шүү дээ?

**Д.Дэлгэрсайхан:** Энэ яг ихрийн хувьд энэ 8 буюу 16 хүний асуудал. Яг ихэр дээр адилхан нэр өгчихсөн 16 ихэр байна гэж. Эцгийн нэр, өөрийн нэр,



*төрсөн он, сар ижил ийм байх магадлал бол чамгүй их байгаа.*

*Гэхдээ бид нар бол зөвхөн энэ танилцуулгатай нэг хаяг дээр адилхан нэртэй хүмүүс нэг онд төрсөн хүмүүс байна шүү гэдгийг л ялгаж мэдээлсэн юм. Нэг хаяг дээр ихэр биш, гэхдээ нэг хаяг дээр байгаа адилхан овогтой, эцэг, эхийн нэр нь адилхан, ижилхэн нэртэй, мөн ижилхэн онд төрсөн ийм хүн гэдгээр. Бид нар олон хувилбараар ялгаж үзэж байгаа юм. Гэхдээ үүнийг яг Ганболд гишүүний асуусанчлан бид нар иймэрхүү тохиолдол байдаг шүү гэдгийг сурталчилж, мэдээлж явна уу гэхээс биш энэ ерөөсөө зөрчил бол мэдээж биш болчхож байгаа юм.*

*Тэгэхээр бас зарим тохиолдолд бид нар яг үүнийг зүгээр анхааруулж ярих үүднээс л энэ мэдээллийг өгсөн юм байгаа юм. Ийм юм байдаг юм шүү гэдэг дээр.*

**Ж.Батсуурь:** *Иймэрхүү тохиолдлуудтай хэдэн хүн байдаг юм бэ гэж асуугаад байгаа байхгүй юу улсын хэмжээнд баримжаагаар? Би ихэр гэж асуухгүй байна л даа.*

*Одоо бид хэд чинь цөөхөн гишүүнтэй юм чинь Ганболд гишүүнийгээ хүндэтгээд бас хүлээчихье хэдүүлээ. Ажил юм чинь. Тэр болтол нэг зүйлийг хэлээд байгаа юм. Хуучин Байнгын хороон дээр ч яригдаж байсан, төсөв ярьж байхад ч яригдаж байсан тэр үед тийм ч техникийн шийдэл байхгүй болчихсон.*

*Ер нь яг тэр банкны мөнгө унадаг шиг л ийм систем рүү орчих юм бол ер нь ихэнх хүмүүсийн хар сар байхгүй болчих юм л гэж. Миний нэр байлаа гэх гээд би Ховд аймагтаа очоод хаана ч, бүүр захын баг дээр өгчихлөө гэх гээд бүүр бусад аймаг дээр ирэнгүүт та өгсөн байна. Өгсөн даруйд унадаг гэдэг юм уу, хасагддаг системээр л явахыг л би голлож өмнө нь олон ярьж байсан.*

*Тэгэхлээр энэ бол төсвийн асуудал шийдэгдчих юм бол өөр зөрчилтэй зүйл байхгүй юм л гэсэн асуудлуудаар гарч ирж байгаа юм байна тээ? Тэгэхлээр үүний дараагийн бид нар энэ шийдэгдчих юм бол үүний дараагийн бид нарын хурал бас нэлээд хөнгөрч ирэх, ахиад дараагийн боломжууд гарч ирэх юм байгаа юм.*

*Би үг хэлэх юугаа аваад ярьчихъя. Ер нь та нар маань мэдээж мэргэшсэн маш олон өндөр технологиор юу яаж байгаа ч гэсэн анхан шатад ямар нөхцөл байдал гардаг юм гэсэн байдлаар бид нар бас яг Дэд хорооны зүгээс явуулсан юм.*

*Тийм болохлоор энийг хувилаад манай референт чинь хэн билээ чи? Баттогтоход би ингээд үүрэг өгчихье. Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн газруудад үүнийг хувилаад хүргүүлээдэхье. Тэгэнгүүт та бүхэн бүүр шүүгээд хамгийн их давхардаж байгаа гомдол юу байна вэ? Дараагийн хурал дээр хэдүүлээ хамгийн их.*

*Ихэр зургаахан, есхөн байдаг гэдэг шиг ганцхан онцгой санал юу байна вэ гээд бүгдийг. Ингээд ер нь нийтдээ энэ аймгуудаас ирсэн энэ юу гэж байна? Сэлэнгэ аймаг, Говь-Алтай аймаг, Орхон аймаг, Өвөрхангай аймаг, Дорнод аймаг, Нийслэлийн иргэдийн хурал, Баян-Өлгий аймаг, Өмнөговь аймаг, Увс аймаг, Булган аймаг, Хэнтий аймаг, Говьсүмбэр аймаг, Ховд аймгаас бүүр маш зузаан юу ирсэн байна. Дархан-Уул аймгаас маш зузаан саналууд ирсэн байна. Архангай аймгаас бүүр маш их зузаан саналууд ирсэн байна.*

*Шаардлагатай бол та бүхэн орон нутаг хариуцсан хүмүүс ерөөсөө ирээгүй, ирээгүй иргэдийн хурлуудаас санал байхгүй гэсэн бичгийг нь бас авмаар байгаа юм. Дараа нь хэдүүлээ янз бүрийн будилаан гарахад миний санал тусаагүй, бид нар хэлсээр байтал гэсэн агуулгыг л хэдүүлээ сая хааж өгөх ёстой л доо. Сая Ганболд гишүүн ч гэсэн ярилаа. Хэдүүлээ хүмүүсийн гарч болох, хардаж болох тэр зүйлүүдийг нь эхэлж хааж өгөөд,*

нарийвчлаад л явъя гэсэн ийм санааг илэрхийлж байна.

Тэгэхлээр энд ирсэн бүх санаануудыг бид нар хувилаад Улсын бүртгэлийн газар хоёрт миний бичгээр хүргүүлчих. Албан ёсоор төдөн хуудастай гээд төдөн аймгийн гээд. Энэ эх хувиа манайхан аваад үлдчих. Ийм зүйлүүдийг хэлнэ.

Дүгнэж хэлэхийн өмнө Ганболд гишүүний асуултад энэ Дэлгэрнаран дарга, Дэлгэрсайхан дарга хоёр хариулчих. Тэгээд тодруулъя. Ганболд гишүүний асуултад хариулъя.

**П.Дэлгэрнаран:** Төхөөрөмжийн сүлжээний судалгааг бид нар хийсэн. Хамгийн сүүлийн ээлжит сонгууль болох 21 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар бол ийм сүлжээгүй газар 461 байсан бол сая 2 сард бид нар хамгийн сүүлд авсан судалгаагаар 223 болж буусан. Энэ оператор компаниудын сүлжээ бол ерөнхийдөө байнга тасралтгүй өргөтгөл хийгдэж байгаа учраас энэ тоо бол уг нь буюгаад байгаа юм. Тэгэхээр бид нар үүнийг бас нэг харъя гэж үзэж байгаа.

Хэрэв энэ тийм онцгой мэдэгдэхүйц буухгүй бол ер нь яах вэ гэдэг вариантуудыг бид нар бодож үзсэн. Старлинкийг хэрэглэе гэдэг ийм хувилбаруудыг бид нар үзээд. Тэгэхээр Старлинк бол яах вэ? Шууд худалдан авахад 1 сая 500 орчим мянган төгрөг байхаар байгаа юм. Үүнийг чинь тээвэр, гааль, сад холбогдох зардлууд ороогүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ яг газар дээрээ аваад яг хэрэглэхэд хэмжээнд ирэхэд бол 2 сая 450 орчим мянган төгрөгийн ийм зардал гарахаар байгаа юм. Нэг Старлинк төхөөрөмжийг. Уг нь үүнийг авчихвал бид нар бас түрээслэх арга байна уу, үгүй юү. Нэг удаа түрээслэх арга байна уу, үгүй юү гээд бас үүнийг судалж байна. Одоо бид нар бол цаг хугацаагаа тооцож үзэж байгаад энэ асуудлыг шийдвэрлэх тийм боломжтой хугацаанд нь арга хэмжээ авна гэсэн ийм тоо тооцоотой байгаа.

Сая тэр Дэлгэрсайхан даргын хэлсэн тэр ирцийн мэдээллийг яахад тэр хөдөлгөөнт сүлжээг оруулах энэ бол манай хоёрт хоёуланд маань маш их ач холбогдолтой ийм юм байгаа юм. Хуучин бол 2 цаг, 3 цаг болоод ирцийн мэдээлэлд нэг хөдөлгөөн ордог байсан бол одоо бол зүгээр цахилгааны тоолуур шиг гүйнэ гэсэн. Ирц бол ийм байнгын хөдөлгөөнтэй, гүйлттэй, шууд бүртгэлийн төхөөрөмж, дээрээс ирц гүйж байгаа учраас энэ саяын Улсын бүртгэлийг ерөнхий газраас гаргасан саналыг хорооны хурлаар гол нь ингэж дэмжээд, манай хоёр бол шууд мэдээллээ нэгтгээд энэ их шуурхай явах юм. Энэ маш их ойлгомжтой болох ёстой. Сая Батсуурь даргын хэлсэн тэр шууд л мэдрэгдэж байдаг, бууж байдаг ийм юм руугаа орох юм гэж ингэж бид нар тооцож байгаа юм.

Энэ хэмжээгээр бас бид нар сүлжээнийхээ асуудлыг шийдэх ямар арга байна гээд Старлинкийг бас судалгааны хэмжээнд байлгаж байгаа.

Төхөөрөмжийн ашиглалтын хугацаа бол ийм байгаа. Одоо бид нар 2493 төхөөрөмжийн хугацааг 25 оны 12 сарын 30 хүртэл сунгасан байгаа. Энэ бол үйлдвэрлэгч компанийнх нь мэргэжилтнүүдийг урьсан. Манайхан өөрсдөө жил болгон техникийн үзлэг, нарийвчилсан үзлэг хийдэг. Ажиллагааг бол байнга туршиж үздэг. Ингээд манайх ажлын хэсэг гарч, дүгнэлт гаргаад, үйлдвэрлэгч компанийнх нь зөвлөмжийг аваад ингээд энэ эд хөрөнгийн хувьд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар ашиглалтын хугацааг сунгах хууль тогтоомжтой. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бид 2493 төхөөрөмжийн ашиглалтын хугацаагаа тэдний тогтоолоор сунгасан эд хөрөнгийнх нь хувьд.

Үйлдвэрлэгч компани бол үйл ажиллагааны ямар нэгэн доголдол гарахгүй. Энэ бол тоо тоолж байгаа

төхөөрөмж учраас энэ тоог бол хуучин байлаа гээд буруу тоолохгүй, шинэ байлаа гээд бас буруу тоолохгүй ингээд ийм учраас манай энэ үйлдвэрлэж байгаа төхөөрөмжийн маань үйл ажиллагаа бол найдвартай гэдэг ийм зөвлөмжийг бид нарт өгч байгаа. Ингээд энэ 2493 төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгаад бид нар техникийн үзлэгүүдийг жил болгон хийж, дүгнэлт гаргаж ингээж явж байгаа.

**Ж.Батсуурь:** Ганболд гишүүнд нэмэлт асуулт байна уу? Хоёр Байнгын хороо асуултаа сольж яриад байна уу? Дэлгэрсайхан.

**Д.Дэлгэрсайхан:** Хоёр асуулт асуусан. Нэг нь хаягтай холбоотой, нөгөө нь сонгуулийн нэрийн жагсаалтад өөрчлөлт хэр ордог юм бэ гэдэгтэй холбоотой байгаа.

Тэгэхээр энэ хаягжуулалтын асуудал бол мэдээж нэлээн томоохон асуудал болсон байгаа. Энэ дээр ер нь том ажлын хэсэг ч байгаа, маш олон байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг гараад энэ хаягжуулалтын тал дээр Улсын бүртгэлийн байгууллага ч гэсэн оролцоод ажиллаж байгаа. Яг тантай санал нэг байгаа юм.

Өөрөөр хэлбэл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ хаягжуулалттай холбоотойгоор иргэдэд яг ойлгуулах, ухуулах, яг хаягжуулалтын байдал ийм байна, та өөрийнхөө мэдээлэлтэй хэрхэн танилцах талаарх энэ бид нар энэ жилийн төлөвлөгөөний хувьд сургалт, сурталчилгааны дэд төлөвлөгөөг нэмж хийсэн юм. Өмнө бол бид нар том төлөвлөгөө дотор яваад байдаг. Бид нарын зүгээс нэмэлт ийм дэд төлөвлөгөө хийсэн юм. Яг энэ дэд төлөвлөгөөнийхөө дагуу энэ сургалт, ялангуяа энэ мэдээллийг өгөх ажил дээр онцгой анхаарч ажиллана.

Яг ямар ажил өнөөдөр хийгдээд явж байна вэ гэхээр. [check.burtgel.gov.mn](http://check.burtgel.gov.mn) гэдэг ийм сайт манай яг албан ёсны сайт

дээр иргэн өөрийнхөө байгаа хаягтайгаа танилцах, энэ өөрийнхөө байгаа хаяг дээр байгаа иргэдийн мэдээлэлтэй бас давхар танилцах энэ бололцоогоор хангах үүднээс энэ сайтыг ажиллуулж байгаа.

Өнөөдрийн тоо баримт би танд дурдъя. 56007 иргэн яг өнөөдрийн байдлаар энэ сайт руу хандаж хаягийн мэдээлэлтэйгээ танилцсан байна. Үүнээс 964 иргэн манай руу хүсэлт гаргасан. Би энэ хаягаа нэмэлт байдлаар шалгуулъя, энэ миний хаяг дээр өөр хүн байна, би энэ хаяг дээр байх ёсгүй гээд маш олон төрлөөр. Төрлийг нь дотор нь хувааж үзсэн. Ингээд эндээс 20.6 хувь буюу 199 нь ямар ч асуудал байхгүй. Шалгаад таны хувьд асуудалгүй байна гэдгийг нь тогтоосон. Зөрчилтэй гарч ирсэн. Өөрөөр хэлбэл өөр хүний миний энэ яг амьдарч байгаа энэ орон сууц, үл хөдлөх миний нэр дээр байна. Гэхдээ миний нэр дээр өөр хүн байна гэдгээр зөрчлөө шийдвэрлүүлсэн 1.8 хувь нь шийдвэрлүүлсэн байна. 18 хүн нь.

Өмчлөл нь дуусгавар болгочихсон тэгээд хаягаа шилжүүлээгүй та бол өөр хаяг дээр байн албан ёсоор. Гэхдээ таны өмчлөл чинь дуусгавар болоод энэ дээр байгаад байна шүү гэдгээр зөвлөгөө авсан 568 нь манайхаас зөвлөгөө авсан. Яг энэ хаягтай холбоотойгоор. Холбогдох бусад яг шийдвэрлэх шатдаа 2.4 хувь нь явж байна. Ийм байдлаар бид нар ийм ажиллагаа зохион байгуулж байгаа.

Сонгуулийн нэрийн жагсаалтад 6-н байгууллагатай холбоотойгоор өөрчлөлт ордог. Улсын иргэний бүртгэлийн үйл ажиллагаатайгаар өөрчлөлт ордог. Тухайлбал хүн насан өөд болоход хасдаг. Шинэчилсэн бүртгэлд хамрагдаад гадаадаас ч юм уу ямар нэгэн байдлаар эсвэл хорих байгууллагаас ч юм уу гарч ирсэн хүмүүс хурууны хээгээ өгөөд шинэчилсэн бүртгэлд ороход энэ өөрчлөлт орж байдаг.

Ерөнхийдөө статистик тоогоор бол 3 янзын тоо би хэлье. 20 онд, ер нь 20

оны Улсын Их Хурлын сонгуулиар 31000 гаруй, 31491 хүн өөрчлөлт орсон байна. Иргэдийн хурал дээр, тухайн оны ИХ дээр 1009, Ерөнхийлөгчийн 21 оны сонгуульд 23672 хүний өөрчлөлтүүд орсон байна.

Ер нь эхний хувилбар 4 сарын 1-ний өдөр гарна. Хамгийн сүүлийн хувилбар сонгууль болохоос 3 хоногийн өмнө дуусгаад бүрэн хэмжээгээр хаагаад, яг боодог. Энэ хоорондуур ер ийм өөрчлөлтүүд бас орж байдаг юм. Өөрчлөлтүүд би түрүүн дээр дурдсан 6-н байгууллагатай холбоотойгоор чадамжгүй иргэд байдаг юм уу, цэрэг цагдаагийн ажилтнууд байдаг юм уу, сонгож шилжих хөдөлгөөн дунд нь хийгдэж байгаа 4 сарын 28-ны өдөр бид нар шилжилт хөдөлгөөнийг зогсооно.

Дээрээс нь сонгогчийн шилжилт хөдөлгөөн гэсэн бас ойлголт байдаг. Өөрөөр хэлбэл итгэмжлэгдсэн юунуудад нь менежер, нэр дэвшигч ч байдаг юм уу, тухайн газраас шилжих энэ бололцоонуудыг бас олгосон байдаг ийм өөрчлөлтүүдээс бас нэрийн жагсаалтууд өөрчлөгддөг юм. Айн? 10.

**Ж.Батсуурь:** Менежер, туслах энэ тэр чинь шилжих хугацаа нь хэднээр хаагдах вэ гэж үү? Ганболд дарга, нэмэлт тодруулах хүн байна уу? Ганболд дарга.

**Г.Ганболд:** Хар машин ярьдаг зүйлд эргэлзэх зүйл байхгүй. Би олон сонгуульд энэ орон нутагт ажиллаж, гараар тоолж, нягталж зөрж байсан тохиолдол ер нь байдаггүй л юм даа. Тэгэхдээ ер нь та энэ тайланг бас өнөөдөр бид нарт зориулж тайлан бэлдсэн байх тээ? Тэр дотор тэр хугацаа сунгах гэдэг юмнуудаа авчхаарай за юу. Хугацааг нь сунгаадаг юу байх вэ техникийн хувьд бол ингээд ажиллагаа нь юу гэдэг юм мэргэжлийн тухайн нэг үйлдвэрлэгч байгууллагаар нь ажиллагаа нь хэвийн байна гэдэг дүгнэлт гаргуулсан л гэдэг юмаар яв тэгэх үү? Тэгэхгүй бол ингээд л хугацаа нь дуусчихсан машин,

ингээд л хугацааг нь сунгачихсан юм шиг тийм л ойлголт монголчууд төрнө л дөө. Тиймэрхүү үг, үсгээс хуртэл хэдүүлээ жаахан болгоомжтой баймаар юм шиг байгаа юм.

Одоо бол би дамжуулалтын хувьд асуудалгүй байх. Бүсээр нь хуучин ингээд л аймаг аймгаар гардаг шиг бүсээрээ шууд л дамжуулчих юм байгаа биз тийм ээ? Тэр дамжуу.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** 1 минут нэмээд өгчихье.

**Г.Ганболд:** Тэгэхээр би Сонгуулийн хороотой холбоотой тэр Старлинк энэ тэрийг ашиглах тал дээр та анхаараарай. Ер нь ашиглах боломжийн талаар хэрэв саналууд хэлэх юм бол бид нар бас энэ харилцаа холбооны Учрал сайдын яамтай яриад ер нь зарим алслагдсан багуудыг бас Старлинкээр туршиж, холбоожуулж үзье гэсэн юмнууд байгаа шүү дээ. Төрийн ажлуудыг хооронд нь уялдуулаад би хэлээд байна шүү дээ үүрэн холбооны сүлжээ тавигдахаас нь өмнө тэр нь ядаж тавиад, үргэлжлүүлээд л тэр баг дээр нь л үлдэнэ шүү дээ тийм ээ? Тийм хэлбэрээр явах юм бол сонгууль ядаж маргаангүй байх чиглэлд бол их чухал юм байгаа юм.

Өөр нэг их санал зөрөөд байх зүйл байдаггүй. Дэлгэрсайхан дарга мэдээллүүдээ урьдчилаад энэ сонгуулийн нэрсийн жагсаалт энэ тэртэй холбоотой иторкууд явуулах, саяын тэр таны хэлээд байгаа юмнууд маш зөв кэйсүүд байна л даа. Энэ кэйсүүдээ ер нь бол маш сайн нийгэмд мэдээлэхгүй бол араас нь нээрээ ямар ч тайлбар өгөөд нэмэр байдаггүй. Урьдчилаад.../минут дуусав./

**Ж.Батсуурь:** Би нэг үг хэлээд өндөрлөе. Мэдээллийг нэлээд өргөн дэлгэрүүлчихсэн. Хоёр байгууллагадаа, та бүхэндээ баярлалаа.

Гарах гарцтай холбоотой асуудлуудыг маргааш Төрийн байгуулалтын байнгын хороо, цаашилбал Төсвийн байнгын хороо холбогдох юунуудаас нь эх үүсвэрийг нь гаргах тал дээр хэдүүлээ хамтарч ажиллая.

Эдгээр шийдвэр гарсны дараа би энэ аймгуудаас ирсэн юугаа хэдүүлээ нэгтгээд нэг удаа, нэг хуралдъя. Ер нь бүх аймгуудаас санал ирчхээд байх юм. Тэгээд чинь сая тулчихсан болохоор үзээж амжаагүй. Тэрийг нэгтгээд. Таныг байхгүй байхад ер нь Старлинкийн үйлчилгээг үндсэндээ шийдвэр нь гараагүй болохоос биш хэрэглэх хэмжээнд болчихож байх шиг байна.

Тэгэхлээр Старлинкийг би сая бас хөдөөд хэрэглэсэн. Хэрэглэхтэй холбоотой бас танайх дотоод журам батлах байх. Зөвхөн дамжуулах биш тухайн бүүр Шаргын цаадах Говь ч гэдэг юм уу тэнд ажиллах хэсгийн хороонд ажиллах хүмүүсийн ажиглагч, намуудын төлөөлөл энэ тэрийг холбоожуулах асуудлыг оруулмаар байна. Тэгж байж итгэл үнэмшилтэй, хараад сууж байгаа хүмүүс чинь интернэт аваад, бүүр шаардлагатай гэвэл тэрийг тавиад хамгийн дээд хэмжээгээр нь бас тэр орчинд нь цацаж ашиглах ч болохгүй зүйл байхгүй.

Үгүй гэх юм бол яг хэсгийн хороо, дарга, нарийн бичиг, намуудын ажиглагч нар, хардаг барьдаг хүмүүсийг нь хэрэглүүлэх юм бол тэр хүмүүс чинь илүү итгэл үнэмшилтэй. Тэгэхгүй зарим нь үзчихээд л, зарим нь нөгөөдүүлийнхээ амыг хараад суугаад байхгүй. Үүнийг нь бас журамлах асуудал дээр нь анхаараарай гэж хэлье. Баярлалаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг өндөрлөж байна.

16.24 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР